

“МАТЕРИАЛИМПЭКС“ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ТУЗ-ИЙН
ДҮГНЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Хувьцаа эзэмшигч гишүүд ээ

Та бүхэнд компанийн хамт олон ТУЗ-ийн гишүүдийн нэрийн өмнөөс чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлж та бүхэнд болон гэр бүл үр хүүхдүүдэд тань шинэ оны ажилд нь амжилт бүтээл, амьдралд нь эрүүл энх, аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Манай орны улс төр , эдийн засаг оюун санааны амьдралд гүн гүнзгий өөрчлөлт орж ардчилал, ил тод байдлын дүнд бий болсон төр засгийн тогтолцоог эдийн засгийн болон эрх зүйн баталгаатай болгох замыг туулж байгаа энэ үед та бид ажил амьдралынхаа эргэлтийн үеийн нэгэн чухал асуудлыг хэлэлцэхээр цуглараад байна.

Техник туслалцааны бааз нэртэйгээр 1957 онд анхны суурь тавигдаж гадаад орнуудаас манай улсад зээл тусламжийн шугамаар аж үйлдвэр, хөдөө аж ахуй барилгын салбарт зориулан нийлүүлэгдэх машин механизм, тоног төхөөрөмж, барилгын материалыг хүлээн авч хадгалах борлуулах үүрэгтэйгээр байгуулагдаж улмаар 1964 оноос барилга сантехник, цахилгааны материалаар улсын хэмжээний барилгын байгууллагуудыг хангаж ирсэн тус компанийн нэр харъяалал, өмчийн хэлбэр нь олон удаа өөрчлөгдсөн ч өнөөг хүртэл үйл ажиллагааны үндсэн чиглэлээ хэвээр хадгалж ирлээ.

Тус компани хувьчлагдаж бүтцийн хувьд шинэ хэлбэрт орсноос хойш бүтэн 17 дахь жилдээ ажиллаж энэ хугацаанд үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, үйлчилгээг хэрэглэгчдэд ойртуулан хөнгөн шуурхай үйлчлэх, гадаад дотоодын түнш байгууллагуудтай харилцах харилцаагаа өргөтгөх, ажилчдын нийгмийн хамгаалал, сахилга дэг журмыг сайжруулах, өртөг зардлыг хямдруулах зорилт тавин ажилласнаар хэрэглэгчдийг барилгын болон өргөн хэрэглээний зарим бараагаар хангах, улс хоорондын тээвэр зуучлал, аялал жуучлалын хүрээгээ нэмэгдүүлэн, барилгын материалын үйлдвэрлэл, барилга угсралтын ажилд боломжийн ахицтай ажиллаж ирлээ

Компанийн бүх гишүүдийн болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлыг хуулийн хугацаанд хийж компанийн бүтэц, орон тоо, цалингийн сан тогтоох, компанийн удирдлагыг сонгох, удирдлагын санг батлах зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж ирсэн бөгөөд Удирдлагын Зөвлөлийн гишүүдийн хурлаар компанийн өмнө тулгарч байгаа асуудлууд, цаашдын ажиллагааны чиглэл зэрэгт хамтын шийдвэр гаргаж ажилласан ба 7 хоног бүр шуурхай цуглаан хийж долоо хоногт хийсэн ажлаа мэдээлж хийх ажлын чиглэлээ тодорхойлж байна

Хувьцаа эзэмшигчдийн дунд олон компанийн хувьцаа эзэмшигч байдгийг харгалзан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуулийн хугацаанд гэхдээ хувьцаат компаниудын хуралтай давхцуулахгүй байх бодлогыг баримтлан ажиллаж байна. Ингэснээрээ хувьцаа эзэмшигчдийг компаниудын хуралд оролцож мэдээлэл авах,

өөрийн хөрөнгийн үр ашгийн тооцоо хийх, улмаар хөрөнгийн зах зээлд ажиллах бололцоо сонирхлыг нэмэгдүүлнэ гэж үзэж байгаа.

Хувьцаат компаниудын нийтлэг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд компанийн засаглалыг сайжруулах, компанийн нийгмийн хариуцлага, гүйцэтгэх удирдлага, ажиллагсадын ажлын болон мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх шаардлага байгаа нь зүй ёсны хэрэг билээ.

Үндэсний 40 гаруй компанитай хамтран ажиллах гэрээтэй бөгөөд гадаадын олон компанитай аялал жуулчлал, тээвэр зуучлалын чиглэлээр хамтран ажиллаж байна.

Тайлант жилийн хүрээнд бидний үйл ажиллагаанд нөлөөлж байсан гадаад, дотоод сайн муу хүчин зүйл байсан. Ам долларын ханш байнга нэмэгдэж байсан нь манай гадаад худалдаа, тээвэр зуучлалын үйл ажиллагаанд сайнгүй нөлөө үзүүлээ. Төгрөгийн ханшийн бууралтаас болж үйлчлүүлэгчдийн худалдан авах чадвар муудаж, хүнсний гол нэрийн бараа болох элсэн чихрийн борлуулалт багасаж бараа эргэлтийн хугацаа уртассанаараа орлого буурах шалтгаан болсон. Доллар ханшийн өөрчлөлтийн улмаас хамтран ажилладаг үндэсний компаниудын борлуулалт буурсан нь компанийн орлого буурахад нөлөөлсөн.

Энэ бүгдээс шалтгаалан тайлант оны эцсээр санхүүгийн байдал хүндэрч байгаа нь мэдрэгдсэн тул зардал бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнээс хамгийн үр ашигтай болсон арга хэмжээний нэг бол банкны өндөр хүүтэй бизнесийн зээлийг бага хүүтэй банкны баталгаагаар солих явдал байлаа. Энэхүү арга хэмжээг авахад олон жил сайн түншийн харилцаатай байсан гаднын компаниудын дэмжлэг ихэд нөлөөллөө. Мөн ачаа эргэлтийн тоо багассантай холбоотойгоор орон тоо, бүтцийг шинэчлэх шаардлагатай байсан ч бид харилцан ярилцаж, орон тоогоо цомхотголгүйгээр тодорхой хугацаанд /20 хоногоос 45 хоногийн хугацаанд/ ээлжлэн амарснаар цалингийн зардлаа хэмнэх арга хэмжээг удирдлага, хамт олноороо шийдвэрлэлээ.

Тайлант онд хөдөлмөр зохицуулалтын болон шаардлагатай асуудлыг шийдвэрлэх, удирдамжийн чанартай баримт бичиг баталгаажуулах зэрэг чиглэлээр 48 тушаал гарлаа, 2015 онд ажиллагсад болон өндөр настан ахмадуудаас 6 өргөдөл хүлээн авч 3 хоногийн дотор асуудлыг шийдвэрлэн хариу мэдэгдсэн ба гадны байгууллага иргэдээс 120 бичиг факс хүлээн авч 561 албан бичгийг гадагш явуулсан бөгөөд компанийн ажиллагсадтай байгуулах хөдөлмөрийн болон эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ, түрээслэгчидтэй байгуулах түрээсийн гэрээнүүд, зарим комиссын үйл ажиллагааны журам, ажилтны ажил үүргийн хуваарь зэрэг удирдамжийн чанартай баримт бичгийг боловсруулан баталгаажуулж мөрдүүлж ирлээ

2015 оны борлуулалт өмнөх оноос буурсан дүнтэй гарсан. Байгууллагын ажлын үр дүн нь ашигт ажиллагаагаар хэмжигддэг боловч санхүүгийн голлох үзүүлэлт хоорондын харьцаа зөв зохистой байх нь маш чухал Энэ нь байгууллагад учирч болох алива эрсдэл хямралыг даван гарахад голлох нөлөөтэй гэж үзэж байна.

2015 онд “Материалимпэкс” ХК ашигтай ажиллаж, татвар нийгмийн даатгалын өргүй шинэ оныг угтсан. Компанийн санхүү эдийн засгийн хэлтэс анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн ажлыг олон улсын нэгдсэн бүртгэлийн стандарт, Монгол улсын хууль, компаниас гарч байгаа тушаал шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажилагаагаа зохион байгуулж сар улирал бүр тайлан гаргаж, Сангийн яам, Нийслэлийн татварын алба болон холбогдох дээд байгууллагуудаар шалгуулан хугацаанд нь тушааж ирсэн байна. Компани нягтлан бодох бүртгэлдээ 2013 оноос Ритус ХХК-ийн “Ноён” санхүүгийн програм нэвтрүүлж компьютерийн дотоод сүлжээ ашиглан санхүүгийн тайлан тооцоог гүйцэтгэсэн байна.

Хагас бүтэн жилээр компанийн нийт хөрөнгөд, сар бүр зарим эд хариуцагчдын хариуцаж байгаа бараа материалд тооллого тооцоо хийж ирснээс гадна ажил нь өөрчлөгдөж байгаа эд хариуцагчдын бараа материалд хүлээлцэх тооллого хийж ирлээ, Тайлант онд үйлдвэрлэлийн цаашдын жигд ажиллагааг хангахын тулд цементийн бункер, компрессорын станцын цемент тээвэрлэх шугаманд хэсэгчилсэн өөрчлөлт засвар, суурин краны болон вагон төмөр замын засварыг бүрэн хийж дуусгалаа,

Мөн онд барилгын угсралтын ажлыг эрчимжүүлж, БНХАУ-ын хөрөнгө оруулалттайгаар “My Town” орон сууцны цогцолбор хорооллын барилгаас эхний ээлжийн 2 барилгын дотоод заслын ажлыг эхлүүлж 2016 оны 1-р улиралд ашиглалтад хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Уг хорооллын дараачийн 2 блокийн угсралтын ажил эхэлж 8-10 давхар хүртэл явсан байгаа. Үүнтэй холбоотойгоор борлуулалтын алба шинээр байгуулагдаж, 70 гаруй орон сууцны борлуулалтыг хийж, гэрээ байгуулаад байна.

2015 онд компанийн гаалийн хяналтын талбайн хэмжээнд 5016 чингэлэг, 6 битүү болон задгай вагонтой ачаа хүлээн авснаас өөрийн компани 1705 чингэлэг хүлээн авсан байна. Солонгос, Япон, БНХАУ, Сингапур, Хонг-конг, Бразил, ОХУ, Малайз, АНУ, Франц, Турк зэрэг орнуудаас чингэлэг хүлээн авсан бөгөөд ирсэн барааны ихэнх нь машин, хүнсний бараа байлаа. Тээвэр зуучлалын үйлчилгээг үйлчлүүлэгчид, хамтран ажиллагч байгуулллагад хөнгөн шуурхай байдлаар явуулахыг өөрийн эрхэм зорилт болгон ажиллаж байна. Үндсэн хэлтсийн дотроос Гадаад худалдаа хамтын ажиллагааны хэлтсийн үзүүлэлтүүд өмнөх оноос буурсан дүнтэй байна.

Тайлант хугацаанд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг ханган ажиллаж давтагдсан тоогоор 42 хүртэл хүнд 4082 удаагийн зааварчилгыг өгч, үйлдвэрлэлийн аваар осолгүй ажиллалаа.

Хямралтай өнөөгийн нөхцөлд байгууллагын үйл ажиллагааны талаар сурталчилгаа сайн хийх нь үйл ажиллагааг идэвхжүүлэх нэгэн хөшүүрэг байх болно. Энэ нь аялал жуучлал, тээвэр зуучлал, барилга угсралт, худалдаа эрхэлдэг манай компанид онцгой чухал зүйл байх болно гэж үзэж байна Энэ дүгнэлт, мэдээлэлд ороогүй олон тоон үзүүлэлтийг санхүүгийн хураангуй болон дэлгэрэнгүй тайлангаас үзэж биднээс асууж тайлбар авна гэдэгт итгэж байна.

Компанийн хэлтэс, нэгжийн болон санхүүгийн тайлан мэдээнээс үзэхэд эдийн засгийн хямралтай жилд сайн ажиллалаа гэж ТҮЗ дүгнэж байна. Цаашдаа хямралыг

бэрхшээл, шалтаг болголгүй улам сайн ажиллах болно гэдгээ хувьцаа эзэмшигчиддээ хэлэх байна.

Компанийн хувьцаа эзэмшигч эрхэм гишүүд ээ.

Бид ололтоо бататган байгууллага хамт олноо гэсэн эрмэлзлийг эрхэм болгон, санаж сэдэж хийсэн бүтээсэн эхлэлийг нь тавьсан ажлуудаа улам төгөлдөржүүлэн сайжруулж, хийж бүтээх ажилдаа тооцоо судалгаатай хандаж, үргүй зардлыг бууруулахад бүх анхаарлаа тавьж ажиллах нь бидний эрхэм зорилт болж байна. Энэ талаар үнэтэй санал зөвлөмжөө өгнө гэдэгт итгэж байна

Та бүхэнд эрүүл энх, аз жаргал хүсэн ерөөе

Анхаарал тавьсанд баярлалаа

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ